



**“ЭРДЭНЭТИЙН ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ**

61021 Орхон аймаг, Баян-Өндөр сум, Баянцагаан баг,
Утас: 7035 0951, Факс: (976) 7035 3718
Цахим шуудан: info@erdenetpp.energy.mn

2021.12.13 № 1/982
танай _____ -ны № _____ -т

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАРТ

“Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн
2021 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний
биелэлтийг гарган хүргүүлэв.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.БАТ-ЭРДЭНЭ

D:\A 2021\Bichig hereg\A5.docx

038030676

**“ЭРДЭНЭТИЙН ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2021 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Д/д	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт
	Хууль тогтоомж, Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр:		
1	Авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэх	Авлигын эсрэг ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, хэрэгжилтийн тайланг тогтоосон хугацаанд АТГ-т хүргүүлэх,	<p>Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалт, Эрчим хүчний сайдын 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 04 дүгээр тушаалын дагуу Гүйцэтгэх захирлын захиргааны шийдвэр гаргах, холбогдох ажилтанд сахилгын шийтгэл ногдуулах, ажил гүйцэтгэх болон худалдах, худалдан авах гэрээ гэх мэт бүх төрлийн гэрээнүүд, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг тухай бүр эрх бүхий албан тушаалтан тус бүрээр гаргуулан авч, ажиллаж хэвшсэн.</p> <p>Авлигын эсрэг хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.6 дахь хэсэг, Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журмын 3 дугаар хэсгийн 3.5 дахь заалт, Авлигатай тэмцэх газрын даргын 2012 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн “Маягт батлах тухай” 91 дүгээр тушаалын дагуу албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд нь компанийн мэдүүлэг гаргагч нараас авч, /их хэмжээний өөрчлөлт/ шинээр томилогдсон мэдүүлэгч гаргагчаас мэдэгдлийг тухай бүртгэн авч, өгөгдсөн маягтуудын дагуу 7 төрлийн тайланг Эрчим хүчний яамны “Эрдэнэтийн ДЦС” ТӨХК-ийг хариуцсан албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон бүртгэх, хадгалах, эрх бүхий албан тушаалтан н.Ихбаярт тайланг хүргүүлсэн.</p>

			<p>COVID-19 вирусын халдвар гарсантай холбогдуулан олон нийтийг хамарсан авлигын эсрэг сургалт сурталчилгааны ажлыг түр хойшлогдсон ч АТГ-аас авлигын эсрэг Хуулийн талаарх анхан болон давтан сургалтанд компанийн эрх бүхий албан тушаалтнууд болох нийт 21 хүн хамрагдсан.</p> <p>Байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг ил тод байлгах ажлын хүрээнд Компанийн олон нийтэд мэдээллэх самбарт хууль, эрх зүйн буланг ажиллуулж, Авлигын эсрэг хууль болон холбогдох хууль, журам, тушаалуудын талаарх мэдээллийг тогтмол шинэчлэн байршуулж, санал, гомдлыг хүлээн авах санал хүсэлтийн хайрцгийг компани дээр ажиллуулж байна.</p>
	<p>Байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагаа, ил тод байдал, хангах</p>	<p>Байгууллагын албан хаагчдыг чадавхижуулах, ур чадвар, шударга байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр сургалтанд хамруулах, чадавхижуулах</p>	<p>Шинээр ажилд орсон ажилтнуудад үйлдвэрлэлийн процес технологи ажиллагаа, ААД, ГАУСД, ХАБЭА, анхны тусламж, ЭХ-ний салбарт мөрдөгдөж байгаа хууль дүрмээр 2 удаагийн 28 цагийн сургалтыг ажлын байран дээр зохион байгуулав. Компанийн хэмжээнд шинээр ажилд орсон ажилтнуудыг мэргэжилтэй, туршлагатай багшийн удирдлаган дор дагалдуулан сургах багш шавийн гэрээг байгуулан ажиллаж байна. Үйлдвэрлэлийн аюултай хүчин зүйлийн үйлчлэл бүхий, эрсдэлтэй, хэвийн бус ажлын байранд ажиллаж байгаа ажилтнуудын техникийн хичээлийн сэдвийг жилийн өмнө боловсруулан алба, хэлтэс, цехийн нийт 435 ажилтнуудыг 8-аас доош хүний бүрэлдэхүүнтэйгээр ариутгал, халдваргүйтэл хамгаалалтын дэглэмийг сахин зохион байгуулав.</p>
<p>2</p>	<p>Байгууллагын албан хаагчдын ур чадвар, шударга байдлыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх</p>	<p>Байгууллагын ёс зүйн дүрмийг мөрдүүлэх, ёс зүйн хорооны үйл ажиллагааг сайжруулж, гишүүдийг чадавхижуулах, зөрчилд хариуцлага тооцох</p>	<p>Эрчим хүчний сайдын 2019 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 196 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Эрчим хүчний салбарын төрийн өмчит байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм”-ийн дагуу Компанийн “Ёс зүйн дүрэм”-ийг Гүйцэтгэх захирлын 2019 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/108 тоот тушаалаар шинэчлэн баталсан. Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах ажлын хүрээнд Компанийн “Ёс зүйн дүрэм”-ийн 3 дахь хэсэгт заасан заалтуудыг удирдлага болгон компанийн нэгжүүдээс нэр дэвшсэн 8 ажилтанг нийт ажилтнуудаас нууцаар санал хурааж, хамгийн олон санал авсан 5 хүнийг Ёс зүйн хорооны гишүүнээр сонгосон. Үйлдвэрчний эвлэлийн хорооны төлөөлөл, ажилтны төлөөллүүд</p>

			<p>оролцсон Ёс зүйн зөвлөлийг Гүйцэтгэх захирлын 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн Б/290 тоот тушаалаар шинэчлэн байгуулж, үйл ажиллагаагаа явуулж байна. Зөвлөлд 2021-онд 2 өргөдөл, гомдлыг хүлээн авч, хорооны хурлаар тухай бүрт нь авч хэлэлцэж, дүгнэлтийг гарган ажилласан.</p>
<p>Хөрөнгө мэдүүлгийг хадгалах, хяналт тавих ажлыг хуулийн дагуу зохион байгуулах</p>	<p>Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, /их хэмжээний өөрчлөлт/ мэдэгдэл, тайлбарыг бүртгэх, хянах, хадгалах ажлыг хуулийн дагуу зохион байгуулах</p>	<p>Авлигын эсрэг хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.6 дахь хэсэг, Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журмын 3 дугаар хэсгийн 3.5 дахь заалт, Авлигатай тэмцэх газрын даргын 2012 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн "Маягт батлах тухай" 91 дүгээр тушаалын дагуу албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд нь компанийн мэдүүлэг гаргагч нараас авч, /их хэмжээний өөрчлөлт/ шинээр томилогдсон мэдүүлэгч гаргагчаас мэдэгдлийг тухай бүртгэн авч, өгөгдсөн маягтуудын дагуу 7 төрлийн тайланг Эрчим хүчний яамны "Эрдэнэтийн ДЦС" ТӨХК-ийг хариуцсан албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон бүртгэх, хадгалах, эрх бүхий албан тушаалт эрх бүхий албан тушаалтан Э.Ихбаярт тайланг хүргүүлж ажилласан.</p>	
<p>3</p>	<p>Эрх бүхий албан тушаалтнууд болон ХАСХОМ мэдүүлэгчдийг чадавхижуулах, сургалт зохион байгуулах, холбогдох гарын авлага, материалаар хангах ажлыг зохион байгуулах</p>	<p>Компанийн хувийн ашиг сонирхлын хөрөнгө орлогын мэдүүлэгч гаргагч нарт Монгол улсын Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн "Жагсаалт батлах тухай" 326-р тогтоол, Монгол Улсын УИХ-ын Байнгын хорооны 2012 оны 04 дүгээр сарын 25-н өдрийн "Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх хянах, хадгалах журам батлах тухай" 05 дугаар тогтоолын дагуу компанийн мэдүүлэг гаргагч нарт мэдүүлгийг цахимаар мэдүүлэхэд анхаарах асуудлаар арга зүйн зөвлөгөөг өгч ажилласан.</p>	

4	Төсвийн сахилга ба, ил тод байдлыг хангаж, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулах ажлыг төлөвлөн хэрэгжүүлж, аудитын үр дүнг үндэслэн холбогдох арга хэмжээг авч ажиллах	<p>1. Шилэн дансны тухай хууль”, “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын хэрэгжилтийг хангах тухай Гүйцэтгэх захирлын 2018 оны 01 дүгээр сарын 04 өдрийн А/02 тоот тушаалаар холбогдох ажилтнуудыг чиглэл тус бүрээр нь үүрэгжүүлэн ажиллуулж байна.</p> <p>2. Шилэн дансны мэдээлэлд улирал бүр дотоод аудит хийж шилэн дансанд тавигдах мэдээлэл болон дуу тавигдсан мэдээллийг нөхөн байршуулахад холбогдох ажилтнуудад зөвлөмж өгч ажилласнаар 2021 оны мэдээллийг бүрэн гүйцэд байршуулсан.</p> <p>3. Шилэн дансны тайланг улирал бүр холбогдох маягтаар гарган гүйцэтгэлийг Эрчим хүчний яаманд тайлагнаж байна.</p> <p>4. ЭХЯ-ны ХШУДАГ-аас шилэн дансанд дотоод аудит хийсэн зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Компанийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг төлөвлөн, 2021 оны Бизнес төлөвлөгөөг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн тус тус батлуулан ажиллалаа. Компанийн санхүү, эдийн засгийн байдал, 2020 оны тайлан балансыг танилцуулж, холбогдох заавар зөвлөгөөг авч ажиллав. Мөн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг танилцуулж, сүүлийн 2 жилд зөвлөмжөөр өгсөн үүргийг хэрэгжүүлэн ажилласан тухай тайланг Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулсан. Шилэн дансны тухай хуулийн 6, 7 дугаар зүйлд заасны дагуу мөнгөн гүйлгээний тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, санхүү байдлын тайлан, аудитын дүгнэлт, өмчийн өөрчлөлтийн тайлан гэх мэт мэдээллийг компанийн вэйб сайт, Шилэн дансанд тухай бүр нь шинэчлэн байршуулж ажилласан.</p>
---	---	---	---

6	<p>Хүний нөөцийн ил тод байдлыг хангах</p>	<p>Шинээр ажилтан сонгон шалгаруулах ажлын ил тод нээлттэй байдлыг хангах /Сул орон тооны зар болон сонгон шалгаруулалт явуулах журам, сонгон шалгаруулалт явуулсан талаарх дэлгэрэнгүй мэдээллийг цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарлах, сонгон шалгаруулалтыг үндэслэн иргэдийг ажилд авах ажлыг зохион байгуулж хэвшүүлэх</p>	<p>Гүйцэтгэх захирлын 2019 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 тоот тушалаар “Ажилтан сонгон шалгаруулж ажилд авах, ажилд шинээр орж буй ажилтны мөрдөх журам”-ыг шинэчлэн батлуулсны дагуу мөрдөн ажиллаж байна. Компанийн 35 МВТ-ын хүчин чадалтай турбогенератор суурилуулах өргөтгөлийн ажлын хүрээнд шаардлагатай боловсон хүчинг хуваарилах тухай асуудлаар орон тооны хязгаарыг тогтоож, орон тоог шилжүүлэх тухай асуудлыг ТУЗ-ийн хуралд танилцуулж шийдвэрлүүлсэн. Компанийн Үйлдвэрчний эвлэлийн хороотой байгуулсан “Хамтын гэрээ”-нд сулласан орон тоонд 20 ба түүнээс дээш ажил ажилласан ажилтнуудын төрсөн хүүхдүүдээс мэргэжил, эрүүл мэндийн хувьд зохих шаардлагыг хангасныг сулласан орон тооны 30 хувиас хэтрэхгүй байх бөгөөд сонгон шалгаруулалтыг жилд 1 удаа явуулах бөгөөд шалгарсан хүүхдүүдийг зарлаж, орон тоо гарсан үед нь ажлын байраар хангах заалтыг тусган батлуулсан. Мөн It инженерийн нээлттэй ажлын байрны зарыг 2021 оны 11 дүгээр сарын 01-нээс 30-ныг хүртэл хугацаанд компанийн веб сайт болон эрдэнэтийн зарын группээр тавьж материалаа ирүүлсэн хүмүүсийн дунд сонгон шалгаруулалт явуулсан.</p>
7	<p>Бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны шуурхай, ил тод байдлыг хангах</p>	<p>Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, явц, үр дүн, тайлан дүгнэлт, хяналт шалгалтын талаарх холбогдох мэдээллийг хуулийн хугацаанд нийтэд мэдээлэх</p>	<p>Манай компани Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгохдоо Сангийн сайдын 2017 оны 07-р сарын 04-ний өдрийн 234 дүгээр тушаалаар батлагдсан “Ерөнхий гэрээ байгуулах журам” 2019 оны 03-р сарын 22-ны өдрийн ТӨНӨХБАҮХАТ хуулийн нэмэлт өөрчлөлт зэргийг мөрдөж, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, Сангийн сайдын 2013 оны 68 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ”-ийг баримтлан ажилласан. Бүх тендер шалгаруулалтын үнэлгээг хийхдээ Сангийн сайдын 2014 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 122 тоот тушаалаар шинэчилэгдэн батлагдсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”-ын 4.5 заалтын дагуу тендер нээсэн өдрөөс хойш 28 хоногт багтаан гүйцэтгэж байна. Бүх тендерийн үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын мэдүүлэг гаргуулж, Шилэн данс,</p>

			<p>Tender.gov.mn цахим хуудсанд үр дүнг тухай бүрт нь тавьж ажилласан. Компанийн 2021 оны Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд</p> <ul style="list-style-type: none"> - Нээлттэй тендер шалгаруулалтаар 27 нэр төрлийн 13,833.8 сая төгрөгийн ажил, бараа, төлөвлөснөөс биелэлт 92,5%-тай. - Харьцуулалтын аргаар 23 нэр төрлийн 739.911 сая төгрөгийн ажил, бараа төлөвлөснөөс биелэлт 97%-тай. - Зөвлөх үйлчилгээний аргаар 2 нэр төрлийн 69.8 сая төгрөгийн үйлчилгээ төлөвлөснөөс биелэлт 100%-тай.. - Гэрээ шууд байгуулах аргаар 17 нэр төрлийн 174.69 сая төгрөгийн ажил, бараа төлөвлөснөөс биелэлт нь 100%-тай. - Шууд худалдан авалтаар 35 төрлийн 151,29 сая төгрөгийн сэлбэг материал төлөвлөгдсөнөөс биелэлт 100%-тай. - Тодотголоор 3 нэр төрлийн 165.734 сая төгрөгийн ажил, бараа төлөвлөснөөс биелэлт 66,6%-тай байгаа бөгөөд нийт дүнгээрээ 92,7%-ийн биелэлттэй байна.
<p>АТГ-аас эрхийнхээ гаргасан шийдвэрийг биелүүлэх, тайлагнах</p>	<p>АТГ-аас ирүүлсэн зөвлөмж, зөрчил арилгуулах, хариуцлага тооцуулахаар хүргүүлсэн албан бичиг, АТГ-ын мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгуулахаар хүргүүлсэн мэдэгдлийн дагуу тодорхой арга хэмжээ зохион байгуулж, үр дүнг тооцсон байх</p>	<p>АТГ-аас ирүүлсэн зөвлөмж, зөрчил арилгуулах, хариуцлага тооцуулахаар хүргүүлсэн албан бичиг, АТГ-ын мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгуулахаар хүргүүлсэн мэдэгдлийн дагуу тодорхой арга хэмжээ зохион байгуулж, үр дүнг тооцсон байх</p>	<p>Авлигатай тэмцэх газрын 2020.01.10-ны 01/371 тоот албан бичгээр өгсөн 7 заалт бүхий зөвлөмжийн дагуу биелэлийг ЭХЯ-руу биелэлтийг хүргүүлэн ажилласан.</p> <p>Авлигатай тэмцэх газраас зөрчил арилгуулах, хариуцлага тооцуулах болон мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгуулахаар хүргүүлсэн мэдэгдлийг өгөөгүй болно.</p>

Хянасан: Захиргаа удирдлагын хэлтсийн дарга

Биелэлт гаргасан: Эрх бүхий албан тушаалтан

 /Х.Баттөр/
 /Т.Баялаг/